



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/193/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор:

Л.Равдандорж

Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.03.04 № 1-6/276

танай _____ -ны № _____ -т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БАЯРМАНДАХ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Мал эмнэлгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Батлагдсан төсвөөс эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах болон бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардлаас хөрөнгө бэлтгэсэн мөн багаж, техник хэрэгсэл бэлтгэх зардлаас засвар үйлчилгээ хийлгэж нийт 14,281.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

440020556

Бичиг хэргийн материал нийлүүлэгч Цэгц утга ХХК-тай хийгдсэн худалдан авалтаас 559.5 мянган төгрөг, шатахууны нийлүүлэгч Шунхлай говь ХХК-тай хийгдсэн худалдан авалтаас 760.0 мянган төгрөгийг нийт 1,319.5 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бичсэн.

Эд хариуцагчийн тайланд анхан шатны баримтгүй нийт 1,335.5 мянган төгрөгийн бараа материал байна. Үүнд: Цэгц утга ХХК-ний 1,150.5 мянган төгрөг, Дэлгэрэх ихэр арвай ХХК-ний 185.0 мянган төгрөг.

Эд хариуцагчийн түлш, шатах тослох материалын тайлан болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт хоорондоо зөрүүтэй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй мөн жолоочийн замын хуудсаар зарцуулалт нь үлдэгдлээс 3,328.3 мянган төгрөгөөр дутагдсан байна.

Шатахууны талоны 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл 190.0 мянган төгрөгийг 2020 оны 01 сард зарцуулсан гэх боловч харилцагч Шунхлай говь ХХК-аас шатахууны талоны 2020 оны зарцуулагдаагүй үлдэгдлийн талаар мэдээлэл авахад 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 205.0 мянган төгрөгийн талоныг зарцуулаагүй байсан.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн 101,941.2 мянган төгрөгийн хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах, данс бүртгэлд тусгах талаар арга хэмжээ аваагүй мөн байгууллагын эд хөрөнгийн тооллогыг чанаргүй зохион байгуулж 140,304.5 мянган төгрөгийн эд хөрөнгийг тоолоогүй орхигдуулсан байна. Шинээр худалдан авсан болон үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө, бараа материалыг бүртгэхдээ тоо, ширхгээр нь бус нийт дүнгээр бүртгэл авсан зэрэг нь эд хөрөнгийн зарцуулалт, үлдэгдэлд хяналт тавих боломжгүй байдалд хүртгэсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт муу байгаагаас хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан, нягтлан бодох бүртгэл алдаатай, бараа материалын дутагдал гарсан зэрэг зөрчлүүд нь Монгол Улсын төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль эрх зүйн акт, УСНББОУС нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1463896734.89</u>	<u>429832529.32</u>
33	АВЛАГА	0.00	573460.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	573460.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1463896734.89	429259069.32
351	Түүхий эд материал	1440878157.09	382783669.52
35110	Тусгай зориулалттай материал	543400.00	3346900.00
35130	Эм боох материал	1440334757.09	379436769.52
354	Хангамжийн материал	23018577.80	46475399.80
35410	Бичиг хэргийн материал	1815370.00	4503155.00
35420	Аж ахуйн материал	9901899.80	5194611.79
35430	Сэлбэг хэрэгсэл	3407010.00	4271900.00
35440	Түлш, шатах тослох материал	1615300.00	190000.00
35470	Бусад хангамжийн материал	6278998.00	32315733.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>602302381.91</u>	<u>859444767.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	602302381.91	859444767.45
392	Биет хөрөнгө	504051048.61	758343323.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	232336935.50	232336935.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18244028.96	-48362161.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88948772.52	230984972.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62415439.27	-80723943.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	289453851.15	81892900.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67171747.13	-60735105.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39815084.20	51513324.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15071648.32	-20843227.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	162925003.51	551442062.43
39215	Хуримтлагдсан элэгдэл	-146525734.59	-179162434.74
393	Биет бус хөрөнгө	98251333.30	101101444.36
39301	Программ хангамж	1180000.00	5030000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-176666.70	-1176555.64
39303	Бусад биет бус хөрөнгө	97248000.00	97248000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2066199116.80</u>	<u>1289277296.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>13524076.90</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	13524076.90
413	Өглөг	0.00	13524076.90
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	13524076.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2066199116.80</u>	<u>1275753219.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2066199116.80	1275753219.87
512	Хуримтлагдсан үр дүн	1993174539.89	1202728642.96
51210	Өмнөх үеийн үр дүн	1993174539.89	1993190539.92
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-790461896.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	73024576.91	73024576.91

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2066199116.80	1289277296.77
---	--	----------------------	----------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4109588498.43	3032381276.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2516149258.43	1875300980.81
120	Нийтлэг татварын бус орлого	2516149258.43	1875300980.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2516149258.43	1875300980.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1005898.00	2089500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2515143360.43	1873211480.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1593439240.00	1157080296.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	587491300.00	496558500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587491300.00	496558500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1005947940.00	660521796.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125419000.00	253791536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	879289440.00	404176630.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1239500.00	2553630.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2043389381.63	3822791745.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2043389381.63	3822791745.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1961173619.50	3813050297.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89188399.96	102136500.00
210101	Үндсэн цалин	71734399.96	77517300.00
210102	Нэмэгдэл	13674000.00	20839200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3780000.00	3780000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11148500.00	12767100.00
210201	Тэтгэврийн даатгал	7581000.00	8681600.00
210202	Тэтгэмжийн даатгал	891900.00	1021400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	713500.00	817100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	178400.00	204300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1783700.00	2042700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13162170.00	19834950.41
210301	Гэрэл, цахилгаан	1949830.00	3577212.71

Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	10451300.00	13198521.70
210303	Цэвэр, бохир ус	761040.00	3059216.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36743902.50	33137993.50
210401	Бичиг хэрэг	5961900.00	7372260.00
210402	Тээвэр, шатахуун	22227650.00	22111003.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2948951.50	2449306.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160000.00	240000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3343949.00	965424.00
210408	Бараа материал ақталсны зардал	2101452.00	0.00
2105	Нормативт зардал	528553514.49	2669332289.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	527593514.49	2669147289.20
210502	Хоол, хүнс	0.00	185000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	960000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16946200.00	41500.00
210604	Урсгал засвар	16946200.00	41500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1206980502.71	829368872.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1205937602.71	827745210.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.00	216000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500000.00	600000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147900.00	176400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55000.00	55000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	400000.00
210807	Газрын төлбөр	100000.00	176262.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58450429.84	146431092.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12641115.00	37123811.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45809314.84	109307280.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82215762.13	9741447.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	6147691.00	100000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6147691.00	100000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76068071.13	9641447.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54235080.53	6294987.95
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21832990.60	3346460.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2066199116.80</u>	<u>-790410468.44</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	51428.52
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	51428.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-51428.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2066199116.80</u>	<u>-790461896.96</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1603270884.00	1159169796.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1794944.00	2089500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1794944.00	2089500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1005898.00	2089500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1005898.00	2089500.00
120009	Бусад орлого	789046.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1601475940.00	1157080296.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	587491300.00	496558500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587491300.00	496558500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1013984640.00	660521796.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	125419000.00	253791536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	879289440.00	404176630.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9276200.00	2553630.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1570529084.00	1144010296.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1570529084.00	1144010296.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1488313321.87	1132983848.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89188399.96	102136500.00
210101	Үндсэн цалин	71734399.96	77517300.00
210102	Нэмэгдэл	13674000.00	20839200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3780000.00	3780000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11148500.00	12767100.00
210201	Тэтгэврийн даатгал	7581000.00	8681600.00
210202	Тэтгэмжийн даатгал	891900.00	1021400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	713500.00	817100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	178400.00	204300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1783700.00	2042700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13162170.00	19834950.41
210301	Гэрэл, цахилгаан	1949830.00	3577212.71
210302	Түлш, халаалт	10451300.00	13198521.70
210303	Цэвэр, бохир ус	761040.00	3059216.00

Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	30073257.50	29028599.50
210401	Бичиг хэрэг	8983170.00	7225390.00
210402	Тээвэр, шатахуун	16925900.00	17949653.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3507351.50	2673306.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160000.00	240000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	496836.00	940250.00
2105	Нормативт зардал	57256985.30	85938336.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56064985.30	83908336.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1192000.00	2030000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24050350.00	6281750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	381350.00	1544000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	4350000.00
210604	Урсгал засвар	23669000.00	387750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1250811913.11	876996612.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1249769013.11	875372950.14
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.00	216000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500000.00	600000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147900.00	176400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55000.00	55000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	400000.00
210807	Газрын төлбөр	100000.00	176262.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12621746.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12621746.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82215762.13	11026447.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	6147691.00	1385000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6147691.00	1385000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76068071.13	9641447.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54235080.53	6294987.95
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21832990.60	3346460.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>32741800.00</u>	<u>15159500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>32741800.00</u>	<u>15159500.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>32741800.00</u>	<u>15159500.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	32741800.00	15159500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32741800.00	15159500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-32741800.00</u>	<u>-15159500.00</u>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-73,024,576.91	-73,024,576.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	-73,024,576.91	-73,024,576.91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	73,024,576.91	0.00	73,024,576.91
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	2,066,199,116.80	2,066,199,116.80
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,024,576.91	1,993,174,539.89	2,066,199,116.80
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,024,576.91	1,993,174,539.89	2,066,199,116.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	16,000.03	16,000.03
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,024,576.91	1,993,190,539.92	2,066,215,116.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-790,461,896.96	-790,461,896.96
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,024,576.91	1,202,728,642.96	1,275,753,219.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	498558500.00	492353012.05	6205488.0	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	498558500.00	492353012.05	6205488.0	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496868300.00	490968012.05	5900288.0	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102136500.00	102136500.00	0.0	100.0
210101	Үндсэн цалин	77517300.00	77517300.00	0.0	100.0
210102	Нэмэгдэл	20839200.00	20839200.00	0.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3780000.00	3780000.00	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12767100.00	12767100.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	8681600.00	8681600.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1021400.00	1021400.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	817100.00	817100.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	204300.00	204300.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2042700.00	2042700.00	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21173400.00	19834950.41	1338449.6	93.7
210301	Гэрэл, цахилгаан	3580200.00	3577212.71	2987.3	99.9
210302	Түлш, халаалт	13888700.00	13198521.70	690178.3	95.0
210303	Цэвэр, бохир ус	3704500.00	3059216.00	645284.0	82.6
2104	Хангамж, бараа материалын зардал	27733700.00	25428599.50	2305100.5	91.7
210401	Бичиг хэрэг	7303400.00	7225390.00	78010.0	98.9
210402	Тээвэр, шатахуун	16465900.00	14349653.00	2116247.0	87.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2760800.00	2673306.50	87493.5	96.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240000.00	240000.00	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	963600.00	940250.00	23350.0	97.6
2105	Нормативт зардал	17716800.00	16271900.00	1444900.0	91.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17484000.00	16041900.00	1442100.0	91.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	232800.00	230000.00	2800.0	98.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6993000.00	6971750.00	21250.0	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	2243000.00	2234000.00	9000.0	99.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4350000.00	4350000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	400000.00	387750.00	12250.0	96.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	307937800.00	307557212.14	380587.9	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	304843200.00	304833550.14	9649.9	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500000.00	216000.00	284000.0	43.2

Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	600000.00	600000.00	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	259600.00	176400.00	83200.0	68.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55000.00	55000.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1500000.00	1500000.00	0.0	100.0
210807	Газрын төлбөр	180000.00	176262.00	3738.0	97.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1690200.00	1385000.00	305200.0	81.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1690200.00	1385000.00	305200.0	81.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1690200.00	1385000.00	305200.0	81.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	498558500.00	492353012.05	6205487.9	98.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	496558500.00	490263512.05	6294987.9	98.7
122005	Орон нутгийн төсвөөс	496558500.00	490263512.05	6294987.9	98.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2000000.00	2089500.00	-89500.0	104.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000000.00	2089500.00	-89500.0	104.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	657,175,336.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	657,175,336.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,175,336.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00
2105	Нормативт зардал	72,135,936.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,335,936.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	581,439,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	581,439,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	660,521,796.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	660,521,796.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	253,791,536.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	404,176,630.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,553,630.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Баярмандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авах ажиллагаа, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, засвар, үйлчилгээ, дотоод хяналт, бодлого үйл ажиллагаанд анхаарах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-өөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх.
- Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах.
- Нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангаж, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “ журам батлах тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 63,404.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 14,606.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 502.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 48,295.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Өгсөн 5,726.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 502,0 мянган төгрөгийн албан шаардлага, 48,295.3 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилт 86 хувьтай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 3,822,843.2 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 7,645.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мал эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 776,921.8 мянган төгрөгөөр буюу 37.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	573.5	573.5
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	1,463,896.7	429,259.1	(1,034,637.7)
Үндсэн хөрөнгө	602,302.4	859,444.8	257,142.4
Нийт хөрөнгө	2,066,199.1	1,289,277.3	(776,921.8)
Өр төлбөр	-	13,524.1	13,524.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,066,199.1	1,275,753.2	(790,445.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,066,199.1	1,289,277.3	(776,921.8)

Авлага дансны үлдэгдэл 573.5 мянган төгрөг болж өссөн нь өмнөх оны санхүүгийн аудитаар тогтоогдсон төлбөрийн актаас нягтлан бодогч, нярав хоёр дээр үүссэн актын төлбөр бүрэн хийгдээгүй байгаа нь шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 573.5 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 429,259.1 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 1,034,637.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны вакцины зарцуулалтыг данс бүртгэлд хийгээгүй байсныг нөхөн зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 859,444.8 мянган төгрөг болж 257,142.4 мянган төгрөгөөр өссөн нь данс бүртгэлд аваагүй байсан болон Мал эмнэлгийн ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжүүлсэн ариутгалын автомашинуудыг данс бүртгэлд авсан нь шалтгаалан байна.

Үндсэн хөрөнгийн данснаас акталсан 27,884.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Нийт төлбөр дансны үлдэгдэл 1,289,277.3 мянган төгрөг болж 776,921.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд зарцуулагдсан бараа материалын зарцуулалтаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 13,524.1 мянган төгрөг болж өссөн нь малын вакцины төлбөрийн үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,275,753.2 мянган төгрөг болж өмнөх оноос 790,445.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Мал эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,077,207.2 мянган төгрөгөөр буюу 26.2 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 1,779,402.4 мянган төгрөгөөр буюу 87.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, АОНДШ, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, урсгал засварын зардлууд байна. Энэ нь өмнөх онд вакцины зарцуулалт хийгээгүй байснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 498,558.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 498,558.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөр 498,558.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 598,558.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 596,558.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 490,263.5 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,089.5 мянган төгрөг нийт 492,353.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 486,147.5 мянган төгрөгийг зарцуулж 6,205.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 492,353.0 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,338.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,444.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь тайлант оны үйл ажиллагаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 253,791.5 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 404,176.3 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 2,553.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахуунд 3,600.0 мянган төгрөг, норматив зардалд 72,135.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 581,439.4 мянган төгрөг нийт 657,175.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 114 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 34 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 916.7 мянган төгрөгийн зөрчлийн 1 төлбөрийн акт, 326,463.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,490.2	1	916.7	1	573.5	38.5
Албан шаардлага	2	326,463.1	2	326,463.1			
Зөвлөмж	1	7,319.6	1	7,319.6			
Нийт дүн							

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 662,700.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 401,509.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 140,304.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 116,222.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, элэгдэл бодуулаагүй 93,638.5 мянган төгрөгийн хөрөнгөнд ашиглах жил, элэгдлийг оруулан залруулсан.
2. Бараа материалын дансанд авсан 34,868.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансны ангиллыг залруулсан.
3. Нэмэлт санхүүжилтийн данснаас хийгдсэн эмийн гүйлгээг залруулахдаа үндсэн санхүүжилтийн дансны эмийн зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр бууруулсан бичилтийг залруулсан.
4. Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн 268,002.5 мянган төгрөгийн хөрөнгийг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 261,191.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 140,304.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4,663.8 мянган төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүллээ. Үүнд:

1. Тайлант онд харилцагч Цэгц хутга ХХК-тай 1,150.5 мянган төгрөг, Дэлгэрэх ихэр арвай ХХК-тай 185.0 мянган төгрөгийн тус тус худалдан авалтууд нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2. Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдсан шатахууны зарцуулалтын баримт хангалтгүй мөн жолоочийн замын хуудсаар баталгаажаагүй 3,328.3 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 116,222.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Монгол Улсын ХХААХҮЯ-аас 2019-2020 онуудад Мал эмнэлгийн газар болон сумдын мал эмнэлгийн тасгийн орон тооны цалин, НДШ, татвар, дотоод албан томилолтын зардлуудыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд баталж уг зардлаас санхүүжүүлэхийг чиглэлийг хүргүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан эдийн засгийн ангиллыг зөрчсөн мөн Мал эмнэлгийн газраас уг

зардлуудыг санхүүжүүлэхдээ тодорхой төсвийн хязгааргүй зарцуулалтыг хийсэн байгаа нь батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, төлбөр, хураамж, багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардлуудаас зориулалт бусаар зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль 6 дугаар зүйл 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйл 16.5.5-т “төсвийн шүүд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “эдийн засгийн ангилалтын заавар”-ийг тус тус зөрчсөн байгаа тул батлагдсан төсвийг зохих эдийн засгийн ангилалтын дагуу зарцуулж, тайлан мэдээнд тусгаж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдэж дууссан боловч ашиглагдаж байгаа мөн данс бүртгэлд байгаа боловч ашиглагддаггүй хөрөнгө байна.

2.2. Эрсдэл: Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг бодитой тооцож ажиллахгүй байгаа нь төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчим алдагдахаар байна.

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй:”1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол 7 дугаар зүйл “хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг

шинэчлэн тогтоох” Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.5 “хэмжигдэхүйц байх” гэж тус тус заасан байдаг тул байгууллагын эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон ашиглалтад хууль, журамд заасны дагуу зохих арга хэмжээг авч ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			дга-2021/193/ста-тшз
Шалгагдсан байгууллагын нэр:	Мал эмнэлгийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эд хөрөнгийн тооллогоор байгууллагын нийт хөрөнгийг тоолоогүй.	140,304.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
2	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, төлбөр, хураамж, багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардлуудаас зориулалт бусаар зарцуулсан байна	14,281.7	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
3	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдэж дууссан боловч ашиглагдаж байгаа мөн данс бүртгэлд байгаа боловч ашиглагддаггүй хөрөнгө байна	101,941.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
4	Үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүй, элэгдэл бодуулаагүй хөрөнгө	93,638.5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
5	Бараа материалын дансанд буруу авсан үндсэн хөрөнгө	34,868.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
6	Нэмэлт санхүүжилтийн данснаас хийгдсэн эмийн гүйлгээг залруулахдаа үндсэн санхүүжилтийн дансны эмийн зардлыг бууруулсан бичилт хийсэн	5,000.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
7	Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн бүртгэсэн	268,002.5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
8	Бараа материалын дансанд анхан шатны баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээ	1,335.5	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
9	Шатахууны зарцуулалт нь жолоочийн замын хуудсаар баталгаажаагүй	3,328.3		Дарга, нягтлан бодогч	Б.Баярмандах, Б.Эрдэнэтуяа
ДҮН		662,700.2			